



# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.05 №23 (23)

## ЗАСГИЙН ГАЗАР

### ДАРХЛААЖУУЛАЛТДАА ИДЭВХТЭЙ ХАМРАГДАЖ, КОВИДГҮЙ ЗУНЫГ ХАМТДАА УГТАЦГААЯ!



#КовидгүйЗуныТөлөө  
#ВакцинааХийлгэе

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ өчигдөр ард иргэддээ хандан хийсэн мэдэгдлийг хүргэж байна.

Монгол ахан дүүс ээ, Эрхэм хүндэт иргэд ээ!

Коронавирус нь дэлхийн эдийн засаг, улс орнуудын Засгийн газарт хүндхэн сорилт учруулж хүн төрөлхтөнд амьдралын цоо шинэ хэв маягийг ганцхан жилийн дотор авчирлаа.

Дэлхийн 11 дайнаас хойш хамгийн олон буюу 2.9 сая хүний амийг энэхүү цар тахал авч одлоо. Цар тахлаас улбаалж дэлхийн эдийн засаг огцом зогсолтод орж, 4.9 хувиар буурсан нь 2009 оны дэлхийн санхүүгийн хямралын хүндрэлээс гурав дахин хүндрэлтэй байна гэсэн тооцооллыг судлаачид гаргажээ.

Миний бие Ерөнхий сайдаар томилогдоод хүн амаа вакцинжуулах нь бидний эхний зорилт гэж хэлж байсан. Цар тахлын голомтод ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээсээ эхлээд үе шаттайгаар Засгийн газрын эхний 100 хоногт багтаан зохион байгуулахын тулд бүхий л боломжоо дайчлан ажиллаж байна. Хүн төрөлхтөн цар тахлыг даван гарах цорын ганц зам нь вакцинжуулалт юм.

Дэлхийн хүн амыг 7 тэрбум гэж үзэж, өдөрт 16 сая хүнийг вакцинжуулахад нийт иргэдийг хос тунгаар хамруулахад багадаа 2 жилийн хугацаа орно гэж тооцоолжээ.

Одоогоор дэлхийн нийт хүн амын 1.8 хувийг хос тунт вакцинд хамруулаад байна. Энэ нь олон улсад вакцины хомсдол үүсгэж байна. Улс орнуудын Засгийн газар бүхэн иргэдээ вакцинжуулахын тулд хичээнгүйлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар 2 дугаар сарын 23-ны өдөр дархлаажуулалтыг эхлүүлснээс хойш өнөөдрийн байдлаар 346 мянга 745 хүн буюу насанд хүрсэн хүн амынхаа 16.3 хувийг дархлаажуулаад байна. Засгийн газраас 4, 5 дугаар сарыг үндэсний хэмжээнд дархлаажуулалтын сар болгон зарлаж байна.

Өнөөдрөөс дархлаажуулалтын хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж, үндэсний хэмжээнд вакцинжуулах ажлыг эхлүүлж байна. Та бид хамтдаа хичээж, иргэдийн маань оролцоо өндөр байж чадвал:

- 5 дугаар сарын 1 гэхэд нийслэлийн насанд хүрсэн бүх иргэнийг


- 6 дугаар сарын 1 гэхэд хөдөө орон нутгийн нийт иргэдээ тус бүр эхний тунд хамруулж

- 7 дугаар сарын 1 гэхэд нийт иргэдээ хос тунгаар вакцинжуулах томоохон зорилт тавин ажиллаж байна.

Дархлаажуулалтдаа идэвхтэй хамрагдаж, ковидгүй зуныг хамтдаа угтацгаая!

## ЦЭРГИЙН ШТАБ

### ХҮҮ НЬ САЙН БАЙГАА ШҮҮ САНАА БИТГИЙ ЗОВООРОЙ



Хэнтий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Цар тахлын халдварын тархалтаас үүдэн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдыг ар гэрийнхэнтэй нь утсан холбоогоор тогтмол "уулзуулж" байна.

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги бүр хугацаат цэргийн алба хаагчдаа ар гэрийнхэнтэйгээ утас болон интернетээр холбогдох ажлыг

Цэргийн штабуудтай хамтран зохион байгуулж хэвшсэн бөгөөд энэ удаа Хэнтий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас тус аймгаас 2020 оны 2 дугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 327 дугаар ангид алба хааж буй байлдагч нарыг ар гэртэй нь zoom программ ашиглан уулзууллаа.

Ээж хүү, аав хүү, ах, эгч нарын дунд халуун дотно яриа өрнөж, амар мэндээ эрэлцсэн сайхан арга хэмжээ болж өнгөрөв.

## ҮЙЛ ЯВДАЛ

### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 326 ДУГААР АНГИД АЖИЛЛАВ



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар Зэвсэгт хүчний анги, салбарын удирдлага, бие бүрэлдэхүүнд батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, эх оронч үзэл, цэргийн алба, офицер, ахлагч нарын ёс зүй, сахилга хариуцлагын талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах зорилгоор Зэвсэгт хүчний 326 дугаар ангид өнгөрсөн Баасан гарагт ажиллалаа. Тус ажлын хүрээнд ангийн

хугацаат цэргийн алба хаагчидтай ажилладаг офицер, ахлагч нартай уулзалт зохион байгуулан үүсээд буй нөхцөл байдлын талаар зарим зүйлийг тодруулж, Батлан хамгаалах салбарын хууль, эрх зүйн шинэчлэл, багаар ажиллах арга барилын талаар зарим үүрэг чиглэлийг өгсний сацуу нийт хугацаат цэргийн алба хаагчидтай санал, сэтгэгдлээ солилцож цэргийн алба, ёс зүй, сахилга хариуцлагын талаар судалгаа хийсэн юм.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
+8	-5

### ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
+37	+24

### АФГАНИСТАН

Өдөр	Шөнө
+15	+6

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.846.00	2.856.00
EUR	3.312.00	3.400.00
CNY	432.00	436.20
RUB	36.60	38.70
JPY	25.37	25.09
KRW	2.42	2.60

## КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	620
НИЙТ БҮРТГЭГДСЭН	10218
ЭДГЭРСЭН	5646
НАС БАРСАН	15

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	45
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	247
ЭДГЭРСЭН	1241
НИЙТ БАТЛАГДСАН	1492

## ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 23  
2021.04.05. /ДАВАА ГАРАГ/

**ХАВРЫН ДУНД ЦАГААЧИН ТУУЛАЙ САРЫН ГУРВАН ХӨХ ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

Үс засуулбал: Эд эдлэл идээ ундаа олдono

Наран ургах, шингэх: 06.22-19.27

Барилдлага: Идэр

Шүтэн барилдлага: Хурьцахуй

Суудал: Хий.

Аргын тооллын 4 дүгээр сарын 5, Сумъяа гараг. Билгийн тооллын 23, Элдэв тэнгэртэн одтой, харагчин хонь өдөр. Өдрийн наран 6 цаг 22 минутад мандан, 19 цаг 27 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лус тахиx, мал худалдан авах, мал түгээх, хийморийн дарцаг хатгахад сайн.

Сахил санваар авах, хануур төөнүүр хийлгэх, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

## "ХҮН-ЭХ ДЭЛХИЙ-САНСРЫН УУДАМ" ҮЗЭСГЭЛЭН 10 ХОНОГ ДЭЛГЭГДЛЭЭ

Хүн төрөлхтний төлөөлөл сансрын уудамд ниссэний 60, Монгол хүн сансарт ниссэний болон сансрын хамтарсан нислэг үйлдсэний 40 жилийн түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сансар судлалын түүхэнд тохиосон онцлог үйл явдлууд, орчин үеийн шинжлэх ухааны ололт, амжилтыг сурталчлан таниулах зорилгоор өнгөрсөн сарын 22-нд "Хүн-Эх дэлхий-Сансрын уудам" сэдэвт үзэсгэлэн Оросын шинжлэх ухаан, соёлын төвд (РЦНК) нээлтээ хийсэн. Тэгвэл өнгөрөн Баасан гарагт уг үзэсгэлэнгийн хаалтын ажиллагаа болж өндөрлөв.



Энэ үеэр Монгол Улс болон ОХУ хоорондын найрамдалт харилцааг хөгжүүлэхэд бодит хувь нэмрээ оруулсан, ойн бусад арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүст талархал илэрхийлж зарим шагналыг гардуулсны дотор Монгол цэргийн музейн захирал, хурандаа Д.Ганзоригт ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар Аугаа эх орны дайны ялалтын 75 жилийн ойн дурсгалын медалийг БНМАУ, ЗХУ-ын баатар, сансрын нисэгч, хошууч генерал Ж.Гүррагчаа болон Оросын шинжлэх ухаан, соёлын төвийн захирал Базархандаев Амгалан Ринчинович нар гардуулан өглөө.

ҮЙЛ ЯВДАЛ

**ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦОО**



Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, хурандаа Б.Баатар 4 дүгээр сарын 2-нд АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Филипп Лүүг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын эхэнд дэд хурандаа Филипп Лүү "Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагчаар томилогдсон баяр хүргэе. Шинээр байгуулагдсан командлагч эхтгэн зохион байгуулах, үйл ажиллагааг нь жигдрүүлэх гээд их ажил таны өмнө байгаа ч

гэсэн биднийг цаг заваа гарган хүлээн авч уулзсанд баярлалаа" гээд тусгай хүчний цэргийн харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд ярилцлаа. Уулзалтаар тусгай хүчний цэргийн чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, хамтарсан сургалт дадлагыг тогтмол зохион байгуулах талаар ярилцсан юм. Ялангуяа хоёр улсын Зэвсэгт хүчин хамтран жил бүр зохион байгуулдаг тусгай хүчний чиглэлийн хамтарсан сургалт, дадлагуудын талаар санал солилцож, цаашдын хамтын ажиллагаагаа тодотгов.

ХИЛИЙН ЧАНАДААС

**БАЯРЛАЛАА, МОНГОЛ УЛСЫН ЭРЭЛХЭГ ДАЙЧДАД**



ИБНАУ-д явагдаж буй НАТО-гийн "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийн багийнхан Афганистаны зургаан цэргийн алба хаагчийн амийг аврахад онцгой гавьяа байгуулсанд бусад орнуудын мөрдэс нэгт нөхдөөс нь талархал дэвшүүлсээр байна.

Тэгвэл Монгол Улсын энхийг сахиулагчдын баатарлаг гавьяа үүгээр зогсохгүй Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж байгаа НҮБ-ын мандаттай "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн мотобуудлагын батальоны цэргийн алба хаагчид

орон нутгийн зэвсэглэсэн дээрэмчдэд барьцаалагдсан энгийн иргэдийг аварсан тухай мэдээ ирлээ.

Тодруулбал, "Юнити" секторын Маёом суурингаас Бентью суурины чиглэлд түлш тээвэрлэж явсан НҮБ-ын түлшний гэрээт байгууллага болох "Тристар" компанийн ажилчид болох Кени улсын 2 иргэнийг орон нутгийн зэвсэгт бүлэглэлийнхэн орон нутгийнхаа хууль бус шалган дээр саатуулан эд зүйлсийг нь дээрэмдэж, улмаар гурван хоногийн туршид хорьж, их хэмжээний мөнгө нэхэмжилсэн юм.

Харин энэ үед НҮБ-ын мандатаар заагдсан холын эргүүлийн үүрэг гүйцэтгэж байсан Монгол Улсын цэргийн багийн энхийг сахиулагчид шуурхай арга хэмжээ авч, зэвсэгт


бүлэглэлийн этгээдүүдтэй хоёр талын уулзалт зохион байгуулж, ярилцсаны дүнд хоёр иргэний амь насыг аварч чадсан байна. Тухайн иргэд биедээ ил харагдах шарх авсан байсан учир монгол цэргүүд цаг алдалгүй ажиллаж, уулзалтаа түргэтгэж, яаралтай суллаж чаджээ. Барьцаалагдсан иргэдийн амь насыг зэвсэгт дээрэмчдээс аварч, НҮБ-ын эд хөрөнгийг хамгаалсан Монгол Улсын энхийг сахиулагчдад НҮБ-ын "UNMISS" ажиллагааны удирдлагууд, секторын штаб болон "Тристар" компанийн удирдлагууд талархал илэрхийлж, "Хэрэв монгол цэргүүд тэднийг авраагүй бол үүсэх эрсдэл, аюул нь маш их байлаа. Баярлалаа, Монгол Улсын эрэлхэг дайчдад" хэмээн онцолжээ.

ТАНЫ СОНОРТ

**ХАЛДВАР ТАРХАХ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ХОРООД**

Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын Орон зайн дүн шинжилгээний бүлэг 3 дугаар сарын 15-30-ны хооронд батлагдсан халдварын 2552 тохиолдлыг мэдээллийн санд бүртгэж, орон зайн дүн шинжилгээний аргачлалаар халдварын эрсдэлийн тархалт, нягтрал, чиг хандлагыг тооцоолсон байна. Уг тооцооллоор улаан өнгөөр үзүүлсэн хороодын нутаг дэвсгэрт халдварын төв голомт үүсэж, халдвар тархах өндөр эрсдэлтэй байгаа юм. Үүнд:

Чингэлтэй дүүргийн 6, 14, Сүхбаатар дүүргийн 1, 2, 10, 15, 18, Баянзүрх дүүргийн 4, 5, 6, 7, 8, 14, 15, 16, 18, 21, 25, 26, Хан-Уул дүүргийн 2, 3, 4, 8, 15, 16, 18, 19, 21, Баянгол дүүргийн 2, 3, 4, 5, 6, 24, Сонгинохайрхан



дүүргийн 3, 6, 12, 14, 15, 17, 18, 27, 29, 37, 41 дүгээр хорооны нутаг дэвсгэр багтаж байна.

ЦАХИМ ШУУДАНД

**ХОЖИМ БАХАРХАН ДУРСАХ ЦЭРГИЙН АЛБА САЙХАН**

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Зэвсэгт хүчний 336 дугаар анги хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчдынхаа төрсөн өдрийг тухайн сард нь багтаан тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай.

Энэхүү уламжлалын дагуу 3 дугаар сард төрсөн хугацаат цэргийн алба хаагчид 3 дугаар сарын 31-ний өдөр төрсөн өдрийн баярын ширээний ард уригдан суусан юм. Энэ үеэр Сэлэнгэ аймгийн Зүүнхараагаас татагдан ирсэн байлдагч Ц.Тэмүүжинтэй хэсэг хугацаанд хөөрөлдөв. Ц.Тэмүүжин 2002 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Сэлэнгэ аймагт төрсөн. Ам бүл 8. Өнөр бүлийн отгон гишүүн маань дунд сургуулиа дүүргээд Зүүнхараагийн чулууны үйлдвэрт ажиллаж аав, ээж, ах, эгч нарын хамтаар хөдөлмөрийн амтыг мэдэрч явсан тэрээр залуу хүн бүр эх орныхоо түүх, соёлоо мэдэж, өнөөдрийг бүтээлцэж, ирээдүйгээ сайхнаар төсөөлж явах учиртай хэмээн ухамсарлан цэргийн албанд морджээ.

Тэрээр "Өргөсөн тангараг, өмссөн хувцас ижил дайчин нөхдийнхөө хамтаар цэргийн эрдэмд



шамдан суралцахын хажуугаар дасгал, гүйлт, гимнастик хийх нь биеийн тамирын багш мэргэжилтэй болох хүслийг минь улам бадрааж байдаг олзуурхаж явдаг. Алба хааж байх хугацаанд олон сайхан дурсамж болон үлдэх зүйлийн нэг бол энэхүү төрсөн өдрийн баяр юм. Сэтгэл шингэсэн баярын ширээ засаж өгсөн дарга нартаа баярлалаа" гэв.

Ахлах дэслэгч А.АЛТАНХУЯГ

**ДУУДЛАГА ХУДАЛДАА”ЗОХИОН БАЙГУУЛЛАА**



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Салбар сурталчлах аяныг ангийн штабаас 7 хоногийн хугацаанд байнгын бие бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагчдын ажлын цаг ашиглалт, албандаа хандах хандлага, сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах, тэдний амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор зохион байгуулав.

Уг аян шинэлэг санаа, бүтээлч байдлаар албаны онцлог, шинж чанарыг харуулж чадсан бөгөөд цэргийн гал тогооны дарга, ахлах

тогооч, ахлагч Б.Туяа даргатай гал тогооны бүрэлдэхүүн нь тус аяны хүрээнд мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, хоолны нэр төрлийг олшруулах, эрүүл хооллох ач холбогдлыг сурталчлах зорилгоор ангийн нийт бие бүрэлдэхүүний дунд хоолны дуудлага худалдааг амжилттай зохион байгуулав. Тэд монгол үндэсний зоог, утаж амталсан шарсан тоорой, мини бялуу, гүзээлзгэнэтэй smoothie зэрэг нэр төрлийн хоол, амттанг хийж дуудлага худалдаанд оролцуулсан юм. Арга хэмжээг цар тахлын хорио цээрийн дэглэмийг хүрээнд явуулсан болно.

**ХУВИЙН МАШИНУУДЫГ ҮЗЛЭГТ ХАМРУУЛАВ**



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Баян-Өлгий аймгийн Замын цагдаагийн дарга, хошууч Ц.Банзрагч, байцаагч, ахмад Б.Тилухабыл, ахмад Б.Мэндбаяр нартай хамтран тус ангийн зэвсэг, техникийн албаны, техник шалгах байрны дарга, ахлах ахлагч З.Цогмандах нар ангийн нийт офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын хувийн машинд үзлэг хийж, замын хөдөлгөөнд оролцохдоо тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор мэдээлэл хийв. Тус арга хэмжээнд нийт 32 машиныг үзлэгт хамруулав.

Дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН